

### 13. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ( Ж-5.8, Х-3-5.2)

Аймгийн төрийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа төрийн байгууллагуудаас төрийн үйлчилгээг ард иргэдэд хэрхэн хүргэж байгаа талаар үнэлгээг 25 асуулгаар хийлгэх захиалгыг аймгийн Үйлдвэрчний эвлэлийн дэргэдэх сургалтын байгууллагаар хийлгэж дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан сум, агентлагийн ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулан дүгнэлээ. Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх 20 агентлагийн менежерүүдийн үйл ажиллагаанд хамт олны үнэлгээг 10 үзүүлэлтээр авч агентлагын ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулан дүгнэлээ.

Тус байгууллага нь 2009 оны 11 сард аймгийн хэмжээгээр 19 суманд ажиллаж түүвэр судалгаанд 2300 иргэнийг хамруулсан байна. Өнгөрсөн онд 965 хүнээс үнэлгээ авч байсан бол энэ жил 2 дахин их иргэнийг хамруулсан байна.

Үнэлгээнд дараах зарчмуудыг чиглэл болгон ажиллаа.

1.Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан түвшин тогтоох зорилгоор үзүүлэлтийг өөрчлөөгүй.

2. Хэрэглэгчийн үнэлгээг сум болон агентлагийн ажил үнэлэхэд оролцуулсан дүгнэсэн.

Үнэлгээг тогтоохдоо 3 – аас дээш оноо авсан бол хангалттай, 2.9-өөс доош үнэлгээ авсан бол хангалтгүй гэж үзсэн бөгөөд энэ үнэлгээний дагуу 25 үзүүлэлтээс 17 үзүүлэлт хангалттай, 8 үзүүлэлт хангалтгүй байна. Энэ нь өнгөрсөн оноос 20 үзүүлэлт 0.1-0.5 –аар ахиж, 5 үзүүлэлт буурсан хэдий ч ерөнхий дүнгээр өнгөрсөн оны түвшинд байна.

Хэрэглэгчийн үнэлгээг хавсарав.

### ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

2009 ОН УВС АЙМАГ

№	Үзүүлэлт	Үнэлгээ
1	Хууль тогтоомж, Засгийн газрын шидвэрийн хэрэгжилт	<b>2.98</b>
2	Гэмт хэрэг, хэв журмыг сахиулах , урьдчилсан сэргийлэх	<b>2.91</b>
3	Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр явуулсан үйл ажиллагааны үр дүн	<b>2.97</b>
4	Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилт	<b>3.09</b>
5	Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	<b>2.90</b>
6	Хүн амын амжиргаанд гарсан өөрчлөлт	<b>2.59</b>
7	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар	<b>2.73</b>
8	Хүнсний хангамж аюулгүй байдал	<b>2.85</b>
9	Өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлын үр дүн	<b>2.99</b>

10	Төрийн албан хаагчид иргэдэд үйлчлэх үүргээ хэрхэн биелүүлж байна	<b>3.17</b>
11	Төрийн үйлчилгээнд хүнд суртал чирэгдэл ямар байна вэ	<b>3.16</b>
12	Та төрөөс хэрэгцээт үйлчилгээ авч чадаж байна уу	<b>3.11</b>
13	Төсвийн зарцуулалт, үр ашиг	<b>3.14</b>
14	эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж	<b>3.21</b>
15	Эмч эмнэлэгийн ажилчдын ур чадвар , харилцааны соёл	<b>3.12</b>
16	Эмнэлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг	<b>3.20</b>
17	Сургалтын чанар	<b>3.34</b>
18	Багш нарын ур чадварын түвшин	<b>3.34</b>
19	Багш нараас эцэг эх сурагчидтай харилцах хамтын ажиллагаа	<b>3.23</b>
20	Соёл урлагын үйлчилгээ	<b>3.20</b>
21	Халамжийн үйлчилгээ	<b>3.26</b>
22	Халамжийн үйлчилгээнд нэн ядуу иргэд хамрагдаж байна уу	<b>3.29</b>
23	Нийгмийн даатгалын үйлчилгээ	<b>3.20</b>
24	Байгаль орчныг хамгаалах үйлчилгээ	<b>3.27</b>
25	Төв суурин газрын тохижилт үйлчилгээ	<b>3.28</b>
<b>ДУНДАЧ</b>		<b>3.10</b>

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ЦОГТ-ОЧИР